

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЯАМДЫН САЙДАЙ 2020 ОНД
БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр

Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай 2019 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд 2019 оны эхний хагас жилд явцын хяналт шинжилгээ, жилийн эцсийн байдлаар хяналт – шинжилгээ үнэлгээг хэлтсүүдээс ирүүлсэн тайлан, нотлох баримтад үндэслэн хийж холбогдох яамдууд гэрээнд заасан хугацаанд нь хүргүүлсэн.

Батлан хамгаалах яамны сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд нууцлалын зэрэгтэй мэдээлэл байдаг тул хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй шууд яамандаа тайлагнагдсан.


Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт– шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 6.7-г үндэслэн 6.3-т заасан аргачлалын дагуу явцын хяналт шинжилгээ хийхэд эхний хагас жилийн байдлаар 69.1 хувийн хэрэгжилттэй байсан бол жилийн эцсийн байдлаар 94 хувийн хэрэгжилттэй болж 24.9 хувиар ахисан үзүүлэлттэй гарсан.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЯАМДЫН САЙД НАРТАЙ 2019 ОНД БАЙГУУЛСАН
ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН
ДҮНГИЙН НЭГТГЭЛ**

№	Яам / сайд/-ын нэр	заалтын тоо	Заалтын тоо					хугацаа болоогүй	дундаж хувь
			100	70	30	0			
1	Монгол улсын Шадар сайд	16	14	2					96.2
2	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд	13	12	1					97.6
3	ЗГХЭГ-ын дарга	21	16	5					92.8
4	БСШУСЯам	125	109	12	2	1	1		95.1
5	Эрчим хүчний яам	15	12	2	1				91.7
6	Барилга хот байгуулалтын яам	68	64	3	1				97.6
7	Эрүүл мэндийн яам	57	39	13	3	2			85.9
8	Зам тээврийн хөгжлийн яам	29	26		2	1			95
9	ХХААХҮЯам	67	52	15					93.2
10	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	39	28	9	2				89.4
11	БОАЖЯам	39	36	3					97.7
12	Сангийн яам	25	22	3					96.4
13	Хууль зүй дотоод хэргийн яам	20	17	2	1				93.5
14	Үндэсний хөгжлийн газар	13	12			1			92.3
Дүн		547	459	70	12	5	1		94

Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 459 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 83.9 хувийг, хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 70 арга хэмжээ нь 12.7 хувийг, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай хэрэгжиж байгаа 12 арга хэмжээ нь 3 хувийг, хэрэгжээгүй буюу 0 хувьтай 5 заалт арга хэмжээ нь 0.9 хувийг, хугацаа болоогүй 1 арга хэмжээ нь 0.9 хувийг тус тус эзэлсэн байна.

Гэрээний үүргийн биелэлтийг 2018 онтой харьцуулан харуулбал:



д/д	Яам /сайд/-ын нэр	Тайлан гаргасан хэлтэс	2018 он	2019 он
1	ЗГХЭГгазар	ТЗУХ	88.9	92.8
2	Монгол улсын Шадар сайд	ТЗУХ	91.2	96.2
3	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд	ХОХБТХ	92.8	97.6
4	БСШУСЯам	НБХ	90.4	95.1
5	Эрчим хүчний яам	ХОХБТХ	90	91.7
6	Барилга хот байгуулалтын яам	ХОХБТХ	91.9	97.6
7	Эрүүл мэндийн яам	НБХ	84.6	85.9
8	Зам тээврийн хөгжлийн яам	ХОХБТХ	91.1	95
9	ХХААХҮяам	ХОХБТХ	84.5	93.2
10	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	НБХ	87.2	89.4
11	БОАЖЯам	ХОХБТХ	93.7	97.7
12	Сангийн яам	СТСХ	97.2	96.4
13	Хууль зүй дотоод хэргийн яам	ХЭЗХ	90	93.5
14	Үндэсний хөгжлийн газар	ХОХБТХ	93.3	92.3
Хэрэгжилтийн дундаж хувь			90.5	94

Гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс хэрэгжилтэд хагас жилээр хяналт шинжилгээ хийж хэрэгжилт удаашралтай байгаа болон хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай заалтуудыг хэлтэс болон агентлагуудад хүргүүлэн улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан ажилласан.

Агентлагийн жилийн эцсийн ажлыг дүгнэх үзүүлэлтэд гэрээний үүргээс тухайн агентлагт хамааралтай заалтын биелэлтийг оруулан дүгнэсэн нь гэрээний үүргийн хэрэгжилтэд ахиц өөрчлөлт гарсан гэж дүгнэж байна. Мөн жилийн эцсээр хэрэгжилт хангалтгүй байсан заалтуудыг 2020 оны төлөвлөлтөд тусгуулахаар зөвлөмж өгсөн.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН САЙД НАРТАЙ 2019 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ
ЗААЛТААС ХЭРЭГЖИЛТ УДААШРАЛТАЙ ХЭРЭГЖСЭН ЗААЛТУУД**

№	Заалт	Биелэлт	Хувь
Нэг. Боловсрол соёл шинжлэх ухааны яам			
1	"Төв халх" дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/	2012 онд "Суурь" ХХК-тай хийсэн гэрээг Боловсрол соёл, шинжлэх ухааны яам үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр сунгасан. Буурь суурийн хөрсөнд шинжилгээ хийж цаашид барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжтой хэмээн дүгнэлт гарсан. барилгын ажлын гүйцэтгэл 20%	30
2	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	ЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 26-ны 388-р тогтоолоор орон нутагт эрх нь шилжиж ирсэн. 2019 оны 5 дугаар сарын 8-ны өдөр тендер зарласан. 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдөр тендерийг нээн гүйцэтгэгчээр "Зуут констракшн" ХХК шалгаран энэ оны ажлын гүйцэтгэл. 30 хувь байна.	30
3	iv. сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролд олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх санхүүжилт болох тусгай зориулалтын шилжүүлгийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахдаа төсвийн захирагч нь төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг мөрдлөг болгож, төсвийн үйл ажиллагааны олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнгээ заавал тайлагнана. с. Боловсролын төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь гаргасан шийдвэртээ тусгасан тухай мэдээллийг сайтад байршуулсан байх	Иргэд, төрийн бус байгууллагаар хяналт хийлгээгүй.	0
4	Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/	ЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 26-ны 388-р тогтоолоор орон нутагт эрх нь шилжиж ирсэн. 2014 онд хийгдсэн магадлалаар орсон зураг, төсвийг дахин шинэчилж магадлалаар зураг, төсвийг хянуулж тендерийг зарлан 3 компани оролцсон боловч тендерийн шаардлага хангах компани гараагүй тул дахин зарлаад байна.	ХБ
Хоёр. Эрчим хүчний сайд			

5	Аймгийн төвд шинээр баригдах дулаан хангамжийн системд ажиллах боловсон хүчнийг сургаж бэлдэх	Шинээр баригдах дулааны станцын техник эдийн засгийн үзүүлэлтэд тусгасан 147 хүний дэлгэрэнгүй судалгааг 10 аймгийн төвийн дулааны станц барих төслийн нэгжид хандасан. Уг судалгаа гарахаар ямар ямар инженер техникийн ажилтан шаардлагатай байгааг үзээд орон нутгийн галлагааны байгууллагын нөөцөөс ажиллах боловсон хүчин болон аймгийн хэмжээнд инженерүүдийн /дулаан, цахилгаан, ус хангамж, ариутгах татуурга, барилгын инженер/ судалгаанаас авч, 2020 онд сургалтын зохион байгуулахаар ажиллаж байна. Эрчим хүчний яам, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ын хамтарсан “Орон нутгийн дулааны эрчим хчүний хэмнэлт, ашиглалтыг дээшлүүлэх сэдэвт 2 хоногийн сургалтанд одоо ажиллаж байгаа уурын зуухнуудын 8 инженерүүдийг хамруулсан. Уг сургалтаар дулааны станцын ус бэлтгэл, түүнийг боловсронгуй болгох, шугамын гидравлик тооцоо, насос, ялтсан бойлерын ашиглалт, угаалтын талаар мэдээлэл авсан.	30
Гурав: Барилга хот байгуулалтын сайд			
6	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-дс “Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрт 2020 хүртэлх хугацаанд “... хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтыг дэвшүүлсэн.	2019 онд Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөрс бохирдуулагч жорлонг цөөрүүлэх, “Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага” MNS5924:2015 стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар заалт тусгасан. “Дундговь-Ус” ОНӨҮГ нь 2019 онд 32 хэрэглэгчийг төвлөрсөн ус хангамжийн системд холбуулахаар техникийн нөхцөл олгосон. Үүнд нийтийн болон хувийн орон сууцны 103 өрх хамрагдаж байна. Төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон бүх хэрэглэгчийн бохир усны асуудлыг төвийн сүлжээнд холбогдох буюу хөрс бохирдуулахгүйгээр соруулах цооногоор шийдвэрлүүлж гүйцэтгэлд мэргэжлийн тусламж үзүүлж, хяналт тавьж ажилласан. Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газраас хэрэгжүүлж буй “Аз жаргалтай иргэн” дэд хөтөлбөрт хамрагдсан өрхүүдээс Айраг, Арвижих, Боржигон, Мандал багуудаас тус бүр нэг өрх сонгон, хашаа, хаалга, бие засах газрыг тохижуулах ажлыг зохион байгуулж эздэд нь хүлээлгэн өглөө. Энэхүү тохижилтын зардалд Тамгын газрын хөрөнгө оруулалтын зардлаас 1,529,900 төгрөгийг зарцуулсан. Говь-Угтаал, Гурвансайхан сумын нутагт орших “Их Газрын чулуу”-нд 8 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулсан “Уяхан замбуу тивийн наран” ардын урлагийн их наадмын үеэр хөрс бохирдуулахаас хамгаалах зорилгоор 40 ширхэг био-00 ашигласан. Мөн тус цогцолборт газарт хатаах технологи бүхий ариун цэврийн 2 байгууламжийг барьсан. Азийн хөгжлийн банкны 20 сая.ам долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Мандалговь хотын 3000м/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн хамт гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох 5,57 км ариутгах татуургын шугам сүлжээ 2020 онд хийгдэнэ. Ингэснээр Боржигон, Арвижих багийн айл өрхийг бохир усны шугаманд холбох нөхцөл бүрдэнэ.	30
Дөрөв: Эрүүл мэндийн яам			
7	Харьяа нутаг дэвсгэрийн сум, өрх, эрүүл мэндийн төвийг аймгийн нэгдсэн эмнэлэгтэй цахимаар холбон мэдээлэл солилцох боломж нөхцөл / шилэн кабель	Эрүүл мэндийн газраас 15 сумын эрүүл мэндийн төвтэй Skype программаар холбогдож цаг үеийн байдал, томуу томуу төст өвчний өнөөгийн байдал зэрэг 7 сэдвээр 5 удаа холбогдсон байна. Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд 2019 оны 3 сард Нэгдсэн эмнэлэгтэй хэрхэн холбогдох болон цахим тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлээр сургалт болж мэргэжилтнүүд	30

	татах, тоног төхөөрөмжөөр хангах/ бүрдүүлнэ	хамрагдсан. Сумдын эрүүл мэндийн төвүүдийг компьютерээр хангах асуудлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь 2020 оны 3 сард нийлүүлэхээр санал ирүүлсэн.	
8	3.2.5.1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хүн амын эрэлт хэрэгцээ салбарын бодлогод нийцүүлэн Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасны дагуу харьяа Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулан тусгай зөвшөөрөл олгох комиссын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллана	2019 онд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь 3 удаагийн хурлаар 7 сумын эм, эргэлтийн сан, 4 хувийн эмнэлгийн тусгай зөвшөөрлийг сунгаж шинээр Сайхан-Овоо суманд эмийн сангийн тусгай зөвшөөрөл олгож ажилласан. Эрүүл мэндийн сайд, Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах талаар санал тавих тухай” 236 албан бичгээр Аймгийн засаг даргад тусгай зөвшөөрлийн комиссыг Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулан үйл ажиллагааг зохион байгуулан ажиллах талаар хүсэлт гаргасан бөгөөд хариуг ирүүлээгүй байна.	30
9	3.2.6.7. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар жилд 1-ээс доошгүй удаа дараах асуудлыг хэлэлцүүлэн хурлаас гаргасан шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллана: <u>Үүнд:</u> - Эх хүүхдийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээ - Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, - Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц - Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан, авч хэрэгжүүлэх арга хэмжээ - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа - Эрүүл мэндийн даатгал, санхүүжилтийн зарцуулалт	1. Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгамдаж буй хүүхдийн эндэгдлийн 9 тохиолдолд хэлэлцүүлэг хийж гарсан дүгнэлт шийдвэрийг Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг зөвлөмж болгон эмнэлэг,эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, зөвлөмжийн дагуу хугацаатай үүрэг өгч хэрэгжилт 95,0 хувьтай байна. Мөн алслагдсан малчин өрхөд явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлэх талаарх төслийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 9,9 сая төгрөг батлуулж хөдөөгийн хүн амын алслагдсан сум, багт амьдарч байгаа иргэдийн 23,4 хувийг үзлэгт хамрууллаа. 2. Зонхилон тохиолдож буй халдварт өвчний эрт илрүүлэлтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар “ДОХ/БЗДХ/ болон сүрьеэгийн илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог”-ны төслийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 5,5 сая төгрөг батлуулан, хийгдсэн ажлын тайланг аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүллээ. 3.Аймгийн эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, стратегийн явцын хяналтыг аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 2 удаа хяналт хийж, хяналтын үр дүнг эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлд танилцуулж зөвлөмж хүргүүллээ. Зөвлөмжийн хэрэгжилт 89,7 хувьтай байна. 4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр дээрх 2 арга хэмжээг аймгийн Улаан загалмайн нийгэмлэг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн.	30
10	3.2.7. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Эрүүл мэндийн	Орон нутгийн хөгжлийн сангаас эрүүл мэндийн үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийн хэмжээг 1 иргэнд 15000 төгрөг байхаар төлөвлөн хэрэгжүүлсэн ажил байхгүй байна.	0

	салбарын санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангаас эрүүл мэндийн үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийн хэмжээг 1 иргэнд 15000 төгрөг байхаар төлөвлөн хэрэгжүүлнэ.		
11	3.2.8. 100 сая төгрөгөөс дээш өртөг бүхий хөрөнгө оруулалт /тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээ/-ийг орон нутгийнхаа төсөвт суулгах арга хэмжээ авч ажиллана.	Хийгдээгүй.	0
Тав: Зам тээврийн хөгжлийн яам			
12	Олон улс, улсын болон орон нутгийн чанартай хатуу хучилттай авто замуудад аймгийн төв, сум сууринд очих чигийн урьдчилсан тэмдэг байрлуулах, дээрх замуудын хөвөөг тодотгосон үргэлжилсэн цагаан зураас тэмдэглэл тавих ажлыг зохион байгуулах	2018 онд Зам тээврийн хөгжлийн яам болон Зам тээврийн хөгжлийн төвд 2019 оны төсөвт тусгуулахаар анхааруулга тэмдэг 47, хориглох тэмдэг 18, дарааллын тэмдэг 21, мэдээлэх тэмдэг 26, очих чигийн урьдчилсан тэмдэг 6 нийт 118 ширхэг босоо тэмдэг, үргэлжилсэн цагаан зураас тэмдэглэлийн хөрөнгийн асуудал шийдвэрлээгүй тул 2019 онд хийгдээгүй.	30
13	“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 3.2.5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтран шаардлагатай сумдуудад Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасыг сонгон Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын дагуу орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авах	Сумдын 2019 оны газар зохин байгуулалтын төлөвлөгөөг 2018 оны 12-р сард баталсан тул газар олгох боломжгүй. Харин сумдын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналыг сумдад хүргүүлэн ажиллаж байна. Уг газрын хэмжээг 1500мх200м хэмжээгээр судалгааг гарган хүргүүлсэн.	30
14	Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч буух түр зурваст хариуцагч томилон, байнгын арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгах	Аймгийн төсвийг 2018 оны 12-р сарын 4-ний өдөр аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн хурлаар баталсан тул 2019 онд ажил хийгдээгүй. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч буух түр зурваст хариуцагчийг сумдын Засаг дарга нарыг томилохоор төсөл боловсруулан ажиллаж байна.	0
Зургаа: Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам			

15	/МСҮТ, Политехникийн коллеж төгсөгчдийг ажлын байраар хангах/ 267	196 төгсөгч буюу 52.3 хувь нь ажлын байраар хангагдсан.	30
16	Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад шинэчлэн тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгохыг мөрдүүлж, хэвшүүлнэ.	Аймгийн Үйлдвэрчний эвлэлтэй хамтран Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 10 аж ахуй нэгж байгууллагад цалин хөлсний үзлэгийг зохион байгуулж ажилласан. Үзлэгийн үеэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага цалин олгодог аж ахуй нэгж илрээгүй. Харин хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулаагүй зөрчил байсан тул эдгээр асуудлуудад зөвлөмж өгч ажилласан.	30
Долоо: Хууль зүй дотоод хэргийн сайд			
17	Шүүхийн шинжилгээний албаны автомашиныг тоноглох, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх.	Шүүхийн шинжилгээний албаны алба хаагч нар шаардлагатай үед ашиглах боломжтой зориулалтын багаж хэрэгсэл бүхий 2 ширхэг цүнх шийдвэрлүүлсэн. Албаны автомашиныг тоноглоход шаардлагатай тоног төхөөрөмжийн төрөл, өртөгийн судалгааг боловсруулж, хөрөнгө санхүүг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлт хүргүүлсэн. Төсвийн тухай хуультай зөрчилдөж, ИТХ-аас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дэмжигдээгүй болно.	0
Найм: Үндэсний хөгжлийн газар			
18	Хөгжлийн бодлого төлөвлөлт болон хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийх чиглэлээр аймаг, орон нутагт хурал, зөвлөгөөн, сургалтыг “Аймаг” -тай хамтран зохион байгуулах	Үндэсний хөгжлийн газраас аймаг, орон нутагт хөгжлийн бодлого төлөвлөлт, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийх чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулаагүй байна.	0

ЗГХЭГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу гэрээний шалгуур үзүүлэлтүүд, хүрэх түвшингийн биелэлтийг тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр нь нотлох баримтад үндэслэн үнэлгээ хийж нотлох баримтын хамт холбогдох яамдуудад хүргүүлсэн.

ХЯНАСАН:
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГАЦ.ЭРДЭНЭСҮРЭН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БИЧСЭН:
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХШУДАХ-ИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭНЭ.ОДОНЧИМЭГ